



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
Т.МӨНХСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛТ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
http://www.parliament.mn

2024.11.04 № 27

Эрүүл мэндийг дэмжих сангийн  
бүрдүүлэлт, зарцуулалтын талаар

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 110 дугаар захирамжаар Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, электрон тамхи, түүнтэй холбоотой асуудлаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг судлан, санал дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахлан ажиллаж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1-т "архи согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, 19.2.3-т "тамхины онцгой албан татварын 2 хувь"-тай тэнцэх хэмжээний хөрөнгийг Эрүүл мэндийг дэмжих сангийн эх үүсвэр байхаар заасан бөгөөд Засгийн газрын 2024 оны "Журам батлах тухай" 78 дугаар тогтоолын 2 дахь заалтад "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам"-ын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн сайдад даалгасан байна.

Ажлын хэсгээс Эрүүл мэндийг дэмжих сангийн эх үүсвэрт архи, согтууруулах ундааны болон тамхины онцгой албан татварын тодорхой хувийг бүрдүүлж буй байдал, зарцуулалтын талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийх шаардлагатай байна гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

- Эрүүл мэндийг дэмжих сангийн бүрдүүлэлтэд архи, согтууруулах ундааны болон тамхины онцгой албан татварыг хуульд заасан хувь хэмжээгээр татан төвлөрүүлсэн байдал болон зарцуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг сүүлийн 10 жилийн байдлаар гаргаж, ирүүлнэ үү.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

О.НОМИНЧИМЭГ